

## 12

ОЛОН УЛСЫН ХОЁРДМОЛ ТАТВАР НОГДУУЛАЛТЫН  
АСУУДАЛ БА ОФФШОРЫН / off-shore/ БИЗНЕС


Х.Эрдэнэчулуун, Б.Батбямба

Улс орон бүр өөрийн хууль тогтоомжоо эрх зүйн харилцааны хувьд иргэншлийн, эсхүл, нутаг дэвсгэрийн зарчимд тулгуурлан тогтоосон байдаг. Хоёрдмол татварын асуудал улс орнуудын татварын хууль тогтоомж өөр өөр байдгаас болж үүсдэг. Өөрөөр хэлбэл, нэг татвар төлөгчид аль нэг орон тухайн этгээдийн иргэншилтэй нь, нөгөө нь орлого олсон газартай нь холбогдуулан татвар ноогдуулснаар үүсдэг харилцаа юм. Түүнчлэн, хоёр орон хоёулаа тухайн татвар төлөгчийг манай оршин суугч хэмээн нотлох, аль аль орон нь татвар төлөгчийн тодорхой орлогыг өөрийн орны нутаг дэвсгэр дээр олсон гэж үзэж байгаа үед хоёрдмол татварын асуудал үүсч болно.

Олон улсын хоёрдмол татвар ноогдуулалт гэдэг нь хоёр буюу түүнээс дээш улс нэг татвар төлөгчид татварын нэг объектэд хамааруулан, ижил хугацаанд холбогдох татвар ноогдуулахыг ойлгоно.

Хоёрдмол татвар ноогдуулалт нь аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг удаашруулах, улмаар бараа үйлчилгээний үнийг өсгөх зэрэг сөрөг үр дагавар, улмаар татвараас зайлсхийх явдалд хүргэдэг. Ийм учраас хоёрдмол татвар ноогдуулахгүй байх, ноогдуулсанаас үүсэх асуудлыг шийдвэрлэхын тулд улс орнууд дангаараа болон хамтраад тодорхой үйл ажиллагаа явуулдаг. Үүнд дараахь аргуудыг хэрэглэдэг.

## Хоёрдмол татвар ноогдуулалтыг арилгах арга.



Гадаадын хуулийн этгээдийн татварын статусыг тодорхойлохдоо "байнгын төлөөлөгчийн газар" гэсэн ойлголтыг ашигладаг. Улс орнууд хоёрдмол татвар ноогдуулахгүй байх тухай хэлэлцээр байгуулахдаа аль нэг орны хуулийн этгээд зөвхөн өөр орны нутаг дэвсгэрт байгаа өөрийн байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан орлого олсон тохиолдолд харьяа улс нь тухайн орлогод татвар ноогдуулж болох талаар тохиролцдог. Хэрэв ийм татварын статусгүй гадаадын этгээд Монгол улсын нутаг дэвсгэр дээр орлого олсон бол холбогдох олон улсын хэлэлцээрийн дагуу Монгол улс дээрх орлогод татвар ноогдуулахгүй. Улс орнууд өөрийн орны нутаг дэвсгэрт гадаадын хуулийн этгээдийн байнгын төлөөлөгчийн газар байгуулахад тодорхой шалгуур, нөхцөл биелүүлсэн байхыг шаарддаг.

Бараг бүх улс орнуудад зарим төрлийн бизнесийн үйл ажиллагаа эсвэл хуулийн этгээдүүдэд татварын таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийн хүрээнд хөнгөлөлттэй нөхцлийг бүрдүүлсэн гэсэн үг юм. Харин зарим орон төрийн бодлогоор дамжуулан гадаадын хөрөнгийг татах үүднээс гадаадын пүүсүүдэд татварын хөнгөлөлттэй нөхцлийг бүрдүүлэх нь бий. Үүн дээр түшиглэж гадаадын хуулийн этгээдүүд тухайн орны нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг. Тухайн орны татварын тогтолцоо бусадтай харьцуулахад арай хөнгөлөлттэй байвал *татварын гавани*, эсхүл,

**татварын амралт** г.м-ээр нэрлэх нь бий. Харин тухайн орны нутаг дэвсгэрийн нэг хэсэгт татвар ногдуулалтын үйл ажиллагаа нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэн, хөнгөлөлттэй хэлбэрээр явагдаж байвал тухайн газрыг **"татварын оазис буюу баян бүрд"** (эдийн засгийн чөлөөт бүс, чөлөөт үйлдвэрлэлийн бүс, нээлттэй хот г.м ) хэмээн нэрлэдэг. Хятад улс эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тал дээр ихээхэн амжилттай ажиллаж, төрөөс тодорхой татварын болон татварын бус хөнгөлөлтүүд үзүүлснээр улсаас бараг хөрөнгө зарахгүйгээр хот байгуулж чадаж байна. Манай орны тухайд Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүс байгуулах асуудал хууль, эрх зүйн орчинг нь бүрдүүлэх, статусыг нь тодорхойлох шатандаа явж байна.

Татварын таатай орчин эсвэл татваргүй бүс зэрэг нь оффшорний компани (англи хэлний **off-shore** буюу эргээс гадна, тусгаарлагдсан) хэмээн нэрлэдэг аж ахуйн нэгжийн тоо ихээхэн нэмэгдэхэд түлхэц болдог. Монгол улсад ийм бүс хараахан байгуулагдаагүй бөгөөд үүнд нөлөөлж буй тодорхой шалтгаанууд бий. Тухайлбал : далайд гарцгүй, хоёрхон оронтой хиллэдэг, бусад арга замаар улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэх нөөц боломж ихтэй зэрэг. Орон нутгийн засаг захиргааны байгууллагын зүгээс ийм пүүсүүдэд дараах нийтлэг шаардлага тавьдаг. Үүнд :

1. Гадаадын хуулийн этгээд тухайн улсын хууль тогтоомжийн дагуу заавал бүртгүүлэх.
2. Бүх үйл ажиллагааны санхүүжилтыг зөвхөн бүртгэгдсэн валютын болон бусад эх сурвалжаар хийх.
3. Орон нутгийн захиргааны байгууллагад жилийн санхүүгийн тайлангаа гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд аудитын дүгнэлтийн хуулбарыг түүнд хавсаргах.
4. Оффшорны бүсийн төсөвт төлөх хураамжаа цаг хугацаанд нь төлөх.
5. Улс орны нутаг дэвсгэрт өөрийн оффисийн оролцоогүйгээр ажил хэргийн үйл ажиллагаа явуулахаас татгалзах.
6. Орон нутгийн оршин суугчийг өөрийн компаний хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болгохоос татгалзах.
7. Нутгийн захиргаанаас тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг бууруулахгүй байх.
8. Нутгийн эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ, бусад баримт бичгийн хуулбар, тамганы дардас зэргийг заасан газар бэлэн хадгалах.
9. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах хүнээ байнга тухайн оронд байлгах.
10. Банкин дахь дансны дугаар, реквизиит, дүрмийн сан, хувьцаа эзэмшигч, захирлын зөвлөлд орсон өөрчлөлтийн талаарх баримт бичгээ хууль ёсоор бүрдүүлэн хадгалах зэрэг болно.

Эдгээр шаардлагыг биелүүлж байж сая оффшорны компани эрх авдаг.

**Оффшорны компани** гэдэг нь оффшорны бүсэд бүртгүүлж, татварын хөнгөлөлт эдлэх эрх авсан бөгөөд нутгийн нөөц ашигладаггүй, бүс нутгийн тэргүүлэгч бус аж ахуйн нэгж юм.

Хэдийгээр бүртгүүлж байгаа пүүсүүд нь бүгдээрээ оффшорны төвд үйл ажиллагаа явуулдаггүй ч тэдгээрт үзүүлэх хөнгөлөлт олон янз байдаг. Оффшорны компаниудад дараах төрлийн үндсэн хөнгөлөлт эдлүүлдэг. Үүнд:

- Татвар ногдуулалтын хөнгөлөлттэй нөхцөл эдлүүлэх,
- Валютын хяналт тавихгүй байх,
- Импортийн үйл ажиллагаа явуулахад гаалийн хөнгөлөлт үзүүлэх,
- Тайлан бүртгэлийн үйл ажиллагааг хялбар болгох,
- Банкны ба худалдааны нууцад баталгаа өгөх,
- Тухайн компанийг олон улсын тавцанд хамгаалах,
- Засаг захиргааны хяналт, шалгалт хийхдээ хөнгөлөлттэй хандах,
- Бизнесийн аюулгүй байдалд баталгаа өгөх,
- Удирдлагын үйл ажиллагаандаа цахилгаан холбоо ашиглахыг зөвшөөрөх гэх мэт.

Оффшорны бизнесийн үндсэн давуу тал нь пүүсүүд үзүүлэх татвар ногдуулалтын хөнгөлөлттэй нөхцөл бөгөөд энэ нь :

- *Татваргүй статустай болох* (Гибралтари, Ирландийн Гернси, Жерси, Мэн, Саркийн арлуудад татвар ногдуулалт байдаггүй (тэгтэй тэнцүү) ).
- *Жилийн татварын төлбөрийг улсаас шууд тэглэх.* (Гернси, Жерси, Мэнийн арлууд болон Карибийн сав нутагт гадаадын компаниудаас жил бүрийн татварын төлбөрийг авахгүй байх тухай хуулиндаа урьдчилан заасан байдаг).
- *Татварын маш бага хувь хэмжээ тогтоох* ( Кипрт оффшорний компанид ногдох ашгийн татвар орон нутгийн компанитай харьцуулбал 10 дахин бага бөгөөд 4.25% байдаг ; Швейцарт гадаадын пүүсүүд зөвхөн хөрөнгийн татварыг 0.05 - 0.25 хувиар төлдөг).
- *Татвараас ангид байх компанийг бүртгэхдээ тусгай хураамж тогтоох* (Панамд бүртгэлийн хураамж 150 US\$ байх жишээтэй ),
- *Татвараас ангид байвал тусгай нөхцөл тогтоох* (Ирландад компани тайлангаа тушаах үед 10 фунтийн хураамж авч тухайн компанийг шинээр бүртгэдэг ) зэргээр хэрэгждэг.

Бүх улс орныг татварын орчингоор нь 3 бүлэгт хувааж болох юм. Нэгдүгээр бүлэгт АНУ, Герман, Япон, Их британи, Франц, Итали зэрэг өндөр хөгжилтэй орнууд орох бөгөөд ашгийн татвар цэвэр ашгийн 40-50% орчим болдог. Эдгээр орнуудын хууль тогтоомж татвараас зугтах явдлаас сэргийлэх зорилгоор аж ахуйн үйл ажиллагааг хатуу хянаж, оффшорийг ашиглах явдлыг нэлээд хязгаарладаг.

Хоёрдугаар бүлэгт хөнгөлөлт бүхий татварын систем ба татварын тусгай хөнгөлөлт бүхий системтэй орнууд хамрагдана (Голланд, Швейцар, Люксембург, Австри ба бусад ). Эдгээр орнуудад барааг экспортлох, банкны хувь болон бусад төрлийн орлогоос авах татвар нэлээд бага байдаг. Энэ нь гадаадын пүүсүүдэд охин компаниа байгуулаж, түүгээр дамжуулан үндсэн үйл

ажиллагаагаа явуулах бус харин хөрөнгө, орлого, барааг дамжуулан өнгөрүүлэх төв болгон ашиглах боломжыг бүрдүүлдэг.

Гуравдугаар бүлэгт хуулиар ашгийн татварыг маш бага тогтоосон (эсвэл огт байдаггүй) ба гадаадын хуулийн этгээдыг бүртгэх үйл явц маш хялбар улс орнууд багтана.

Оффшорны бүсүүд дэлхийн бөмбөрцгийн нэлээд хэдэн газар төвлөрсөн байдаг.

**Карибийн сав нутаг** – Багам, Виргинск, Кайманов, Барбадос, болон Гренадийн арлууд.

**Газар дундын тэнгис** – Андора, Гибралтар, Ионако, Кипр.

**Европ** – Швейцар, Люксембург, Лихтенштейн, Ирланди, Сан-Марино болон Гернси, Жерси, Мэнийн арлууд.

**Арабын орнууд** – Ливан, АНЭмират улс, Бахрейн.

**Африк** – Сейшелийн арал, Либер.

**Ази-Номхон далайн бүс** – Хятад, Хонконг, Сингапур, Малайз, Филиппин.

Оффшорны бизнесийн талаар дараах үндсэн дүгнэлтийг хийж болох юм.

- Оффшорны компани – **худалдааны зуучлагч**. Гадаад худалдааны явцад худалдагч, худалдан авагч хоёрын хооронд ашгийн хэмжээг тэнцвэржүүлж, нэмэгдүүлэхийн тулд компани байгуулдаг.
- Оффшорны компани – **зувчуулагч**. Энэ тохиолдолд компанийг, зарлага нэмэгдүүлэх замаар барааны өөрийн өртгийг өсгөн, улмаар татварын суурийг багасгах зорилгоор ашигладаг.
- Оффшорны компани – **үнэт зүйлсийн эзэн**. Энэхүү схем нь өмч хөрөнгөний эзэн өөрийн эзэмшлийн зүйлээ эзэмшдэг гэдгээ нуух зорилгоор компани байгуулна гэсэн үг.
- Оффшорны компани – **барааны тэмдэгтийн эзэн ба түүнийг түрээслэгч**. Тогтворгүй улс оронд бизнес эрхлэх явцад барааны тэмдэгтийн эзэн нь дээрх компани болж ямарч тохиолдолд түүнийгээ авч үлдэж, цааш нь ашиглах боломжтой гэсэн үг.
- Оффшорны компани – **зохиогчийн эрхийн эзэн**. Бизнесийн үйл ажиллагааны гол цөм нь зохиогчид байж бизнес түүнээс хамааралтай бөгөөд үүгээрээ дамжуулан ихээхэн орлого олдог бол оффшорны компани ашигласнаар хууль ёсоор татвар багасгах боломжтой болно.
- Оффшорны компани – **банкны данс баригч**. Энэ схемийн дагуу эзэн тухайн компаныг хяналтандаа авч улмаар уг компани нь банкинд данс нээснээр үйлдвэрлэлийн зардлыг бүрэн хянах боломжтой болно.
- Оффшорны компани – **барьцаа баригч**. Хэн нэгэн өмч эзэмшигч түүнээ хадгалах болон бусад эрсдлээс хамгаалах зорилгоор оффшорны бүсэд компани байгуулна гэсэн үг.
- Оффшорний компани – **хөрөнгө оруулагч**. Гадагш гаргасан хөрөнгөө эргүүлэн элдэв татваргүйгээр өөрийн оронд оруулах хууль ёсны боломжийг гацхүү оффшорны компани олгоно.

- Оффшорны компани – **хөлөг онгоц эзэмшигч**. Хөлөг онгоцоо оффшорны компани, бүс нутгийн далбаан дор хөвүүлэх нь маш олон талын ашигтай байдаг.
- Оффшорны компани – **барилгын ажил гүйцэтгэгч**. Хэрэв ямар нэгэн оффшорны төв тухайн улстай хоёрдмол татварын гэрээ байгуулсан байвал тэр бүсийн компаниар дамжуулан тухайн оронд ажил гүйцэтгэх нь олон төрлийн татвараас чөлөөлөгдөнө гэсэн үг.

Орчин үеийн санхүүгийн болон бусад хэлбэрийн хөрөнгө оруулалт оффшорны төвүүдээс хийгдэх нь элбэг болж байгаа бөгөөд дээр дурьдсан бүс нутгууд нь тодорхой төрлөөр дагнаж, мэргэшин түүндээ гол анхаарлаа хандуулах байдал газар авч байна. Тухайлбал санхүүгийн зуучлалын чиглэлээр Лихтенштейний, даатгалын чиглэлээр Киприйн, хөлөг онгоц эзэмших чиглэлээр Либерийн, экспорт импортын чиглэлээр Швейцар, Голландын, хөрөнгө оруулалтын чиглэлээр Бермудын арал, Гибралтарийн оффшорны компаниуд ихээхэн дагнасан байдаг. Нөгөө талаар оффшорны бизнесээр дамжин олон улсын хэмжээнд бохир мөнгө угаах үзэгдэл нэлээд гардаг нь улс орнуудыг үүнээс болгоомжлоход хүргэдэг. Жишээ нь өнгөрсөн оны дүнгээр ОХУ-д гадаадын шууд хөрөнгө оруулалтаар Кипр улс тэргүүлсэн ба үүний дийлэнх хэсгийг оросын мафийн гадаадад гаргасан бохир мөнгө эзэлдэг гэсэн албан ёсны бус мэдээлэл байна.